ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 сарын 05 № 26/49 Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Татварын хэлтэс 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар **4,367,666.00** /дөрвөн сая гурван зуун жаран долоон мянга зургаан зуун жаран зургаан/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг албан хаагчид нийт **1,350,000.00** /нэг сая гурван зуун тавин мянган / төгрөгийн түлш, халаалтын хөнгөлөлт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.3 */Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно/*-ийг тус тус зөрчсөн байна.

2. Батлагдаагүй орон тоонд 1,441,268.00 /нэг сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга хоёр зуун жаран найман/ төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, 16 дугаар зүйлийн 16.5.3 */батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/* дахь заалтыг тус тус зөрчсөн.

3. Ажилтнуудад албан томилолтын хуудасгүй 657,800.00 */зургаан зуун тавин долоон мянга найман зуун* / төгрөгийн томилолтын зардал олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 */анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/*, 13.7 */анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/* дахь хэсгийг тус тус зөрчсөн.

4. Суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан хаагч автомашин хэрэглэж 918,598.00 */есөн зуун арван найман мянга таван зуун гучин найман/* төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дах заалт /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тушаалын хавсралтыг тус тус зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, тус хуулийн 15.2.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1-т /*... дараах алдаа зөрчилд төрийн аудитын газар албан шаардлага өгнө*/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 04 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг Татварын хэлтсийн төсвийн шууд захирагч М.Туяацэцэг, нягтлан бодогч Н.Долгорсүрэн нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:** **ЗӨВШӨӨРСӨН:**

АХЛАХ АУДИТОР Т.БАТСАЙХАН ДАРГА М.ТУЯАЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ Н.ДОЛГОРСҮРЭН

4817144213
ЗЮА0039 9033475

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

| | |
|---|---|
| Ажлын баримтын нэр: | *Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл* |
| Ажлын баримтын дугаар: | *B501* |
| Аудитын код: | **ДУА-2020/80/СТА-ТШЗ** |
| Аудитын нэр: | **Дундговь аймгийн Татварын хэлтэс** |

төгрөгөөр

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Зардлын дансатай холбоотой асуудал | 1 | Батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон. | 1,441,268.00 | Албан шаардлага өгөх | 2020.01.30 өдрийн 18 цаг 10 минутад ТШЗ, нягтлан бодогч нарт танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. | Зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах; | Албан шаардлага өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | М.Туяацэцэг<br>Н.Долгорсүрэн |
| 2 | Зардлын дансатай холбоотой асуудал | 1 | Ажилтнуудад албан томилолтын хуудасгүй томилолтын зардал олгосон. | 657,800.00 | Албан шаардлага өгөх | 2020.01.30 өдрийн 18 цаг 10 минутад ТШЗ, нягтлан бодогч нарт танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. | Зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах; | Албан шаардлага өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | М.Туяацэцэг<br>Н.Долгорсүрэн |
| 3 | Зардлын дансатай холбоотой асуудал | 1 | Төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг албан хаагчид түлш, халаалтын хөнгөлөлт олгосон. | 1,350,000.00 | Албан шаардлага өгөх | 2020.01.30 өдрийн 18 цаг 10 минутад ТШЗ, нягтлан бодогч нарт танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. | Зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах; | Албан шаардлага өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | М.Туяацэцэг<br>Н.Долгорсүрэн |
| 4 | Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл | 1 | Суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан хаагч автомашин хэрэглэж зардал гаргасан. | 918,598.00 | Албан шаардлага өгөх | 2020.01.30 өдрийн 18 цаг 10 минутад ТШЗ, нягтлан бодогч нарт танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. | Зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах; | Албан шаардлага өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | М.Туяацэцэг<br>Н.Долгорсүрэн |
| | | | | 4,367,666.00 | | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бэлтгэсэн: | Т.Батсайхан | Огноо: | Зөвшөөрсөн: | Дарга: | М.Туяацэцэг |
| Анхан шатанд хянасан: | Х.Наранцацрал | Огноо: | | Нягтлан бодогч: | Н.Долгорсүрэн |
| Хоёр дахь шатанд хянасан: | П.Төвсанаа | Огноо: | | | |

4817144213
ЗЮА9039 9033475

ТУ30015 ... 4817153591